

6

ЭКСПОРТЫН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААРХ МАРГААНТАЙ АСУУДЛУУД

3.Бороо

I. Оршил

1959 онд хамгийн анхны чөлөөт бүс болох Ирландын Шанноны экспортын чөлөөт бүс байгуулагдсан цагаас хойш экспортын чөлөөт бүс байгуулах орнуудын тоо нэмэгдсээр 1980-аад онд гуч, 1990-ээд онд жард хүрсэн байна. Ганц экспортын чөлөөт бүс бус худалдааны, хөдөө аж ахуйн, аялал жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн бүсүүдийг хамруулан авч үзэхэд 1990-ээд онд дэлхий даяар нийт 845 гаруй бүс, 2006 онд нийт 130 оронд 3,500 гаруй бүс байгуулагдсан байна. Монгол Улсын тухайд 2002 оны 6 сард Алтанбулаг худалдааны чөлөөт бүс, 2003 оны 6 сард Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс, 2003 оны 12 сард Цагаан нуур худалдааны чөлөөт бүс байгуулах хуулиуд батлагдсан. Тэр цагаас хойш эдгээр бүсүүдийг хөгжүүлэх, ашиглахтай холбоотой асуудлууд тасралтгүй яригдсаар байгаа.

UNCTAD(1985) “Экспортын чөлөөт бүсийг хөрөнгийн хуримтлалыг бий болгох, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, экспортыг нэмэгдүүлэн гадаад валютын орлогыг өсгөх замаар үндэстний эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлдэг.” гэсэн байдаг. Энэ ч утгаар экспортын чөлөөт бүс байгуулах ажил олон арван жилийн турш тасралтгүй явагдаж ирсэн гэж хэлж болно.

Чөлөөт бүс гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий тухайн улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлдэг. Харин экспортын

чөлөөт бүс гэж тэргүүний, дэвшилтэт технологи бүхий, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүгийн үйлдвэрлэж борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэрлэлийн бүсийг хэлнэ. Экспортын чөлөөт бүсэд татварын хөнгөлөлттэй нөхцөл, аж ахуйн нэгжийн бүртгэлийн хөнгөвчилсөн журам, шалган нэвтрүүлэх хялбарчилсан горим үйлчилнэ. Мөн хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифийн бус хязгаарлалт тогтоохгүй.

Дэлхий дээр өнөөдөр асар их хэмжээний төсвийн хөрөнгө оруулалтаар бүс байгуулаад түүнийхээ эдийн засгийн нөлөө, үр өгөөжөөс хүртэж чаддаг улс орнууд байхад тэгж чаддаггүй улс орнууд бас байдаг. Энэ нь экспортын чөлөөт бүсийн зардал ашгийн харьцаа улс орон бүрт янз бүр тусдаг гэсэн үг юм.

Уг судалгаа экспортын чөлөөт бүсийн эдийн засгийн үр нөлөөг зардал ашгийн дүн шинжилгээний ойлголт дээр тулгуурлан авч үзэх бөгөөд хөгжиж буй улс орнуудын туршлагыг судалгааны тайлбар жишээ болгон ашиглахыг зорьсон болно.

II. Экспортын чөлөөт бүсийн зорилго ба эдийн засгийн үр нөлөө

Экспортын чөлөөт бүсийн зорилгыг түүний эдийн засгийн үр нөлөөтэй холбож тайлбарлах нь зүйтэй. ESCAP/UNCPE(1985)-ын судалгаа экспортын чөлөөт бүсийн эдийн засгийн салбарт үзүүлэх үр нөлөөг урт, богино хугацаанд хувааж үзсэн байдгаас ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэргүүний дэвшилтэт технологи нэвтрүүлэх, экспорт, гадаад валютын ашиг орлогыг нэмэгдүүлэх зэрэг нь богино хугацааны үр нөлөөнд орсон байдаг. Нэг үгээр богино хугацаанд үр ашгаа өгөхөөс гадна тоо хэмжээгээр илэрхийлэгдэх боломжтой эдийн засгийн үзүүлэлтүүдийг үүнд багтаасан байна. Харин бүсийн үйл ажиллагааны нөлөөгөөр дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэл, менежментийн арга барил сайжирч, энэ нь цаашдаа эдийн засагт таатай нөлөөлөхийг урт хугацааны үр нөлөөнд оруулсан байна.

Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх

Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх явдал экспортын чөлөөт бүсийн үндсэн зорилгын нэг байдаг. Эдийн засаг хөгжөөгүй, ажилгүйдэл ихтэй орон нутгуудад зонхилж байрладгаас “бүсийн алтернативийг ажилгүйдэл, бага түвшний ажил эрхлэлт, аль эсвэл бүсийн ажилчид хөдөөгийн амьдралдаа эргэн орох явдал”-аар орлуулж тайлбарлах нь ч бий(Madani, 1999).

Экспортын чөлөөт бүс шууд ба шууд бус хэлбэрээр ажил эрхлэлтийг бий болгодог. Бүсэд бүртгэлтэй компанид ажил орох нь шууд, хоол хүнс, орон сууц

хангамж, сургууль, эмнэлэг г.м. бүсийн жигд үйл ажиллагааг хангах үйлчилгээний салбарын ажил эрхлэлт шууд бус хэлбэрт орно.

Экспортын чөлөөт бүс г.м. чөлөөт бүсүүдийн шууд хэлбэрийн ажил эрхлэлтийн хэмжээ харьцангуй бага байдаг тухай харуулсан судалгаанууд байдаг. Тухайлахад, FIAS(2008)-ын судалгаа эдийн засгийн чөлөөт бүсэд ажиллагсдын тоо дэлхийн нийт ажил эрхлэлтийн 1%-д ч хүрдэггүй гэсэн тооцоог гаргасан байна. Америк тив, Ойрхи Дорнод болон Хойд Африк гэсэн цөөн тооны газруудад л энэ тоо 1%-аас үл ялиг их хэмжээтэй гарчээ. /Хүснэгт 1./

Хүснэгт 1. Эдийн засгийн чөлөөт бүсүүд дэх ажил эрхлэлтийн байдал

| | Шууд хэлбэрийн ажил эрхлэлт (сая) | Нийт ажил эрхлэлтэд эзлэх хэмжээ(хувь) |
|-------------------------------|-----------------------------------|--|
| Дэлхийн хэмжээнд | 68.441 | 0.21 |
| Ази, Номхон Далай | 61.089 | 2.3 |
| Америк тив | 3.084 | 1.15 |
| Баруун Европ | 0.179 | - |
| Төв болон Зүүн Европ, Төв Ази | 1.590 | 0.001 |
| Ойрхи Дорнод болон Хойд Африк | 1.458 | 1.59 |
| Доод Сахарын улсууд | 1.040 | 0.20 |

Эх сурвалж: FIAS. (2008). *Special Economic Zones performance, lessons learned, and implications for zone development*, April 2008, The Office of the Publisher, The World Bank W.D.C., p.34.

Үүнтэй эсрэгээр бүсийн шууд бус хэлбэрийн ажил эрхлэлтийн хэмжээ бодитой түвшинд явагддаг тухай харуулсан судалгаанууд байдаг. Basile(1984) судалгаандаа Египетийн экспортын чөлөөт бүсэд нэг шинэ ажлын байр бий болоход үүнтэй холбоотой эдийн засгийн салбарт нэг ажлын байр, Тайланд бүсийн хүрээний нэг ажлын байр үүнтэй холбоотой салбарын дөрвөн шинэ ажлын байрыг бий болгодог тухай дурьдсан байдаг.

Экспортын чөлөөт бүсэд нарийн мэргэжил, ур чадвар шаарддаггүй, хямд төсөр ажиллах хүчинд суурилдаг, угсрах, оёх хэлбэрийн үйлдвэрлэл зонхилдгоос бүсийн ажиллагсдын 70-80% нь 16-25 насны эмэгтэйчүүд байдаг. Тухайлбал, 1980-д онд Малайзын экспортын чөлөөт бүсэд ажиллагсдын 84%-ийг эмэгтэй ажилчид, нийт үйлдвэрлэлийн 89%-ийг цахилгаан бараа, гутал хувцасны үйлдвэрлэл эзэлж байв. Энэ утгаар нь FIAS(2008) “Чөлөөт бүсүүд урьд нь ажил эрхэлж байгаагүй эмэгтэйтэйчүүдийг ажлын байраар хангахад үр дүнтэй арга хэрэгсэл байж болох юм.” гэж тодорхойлсон байдаг. Бүсийн ажиллагсдын “шилжих хөдөлгөөн” сард дунджаар 5-10%-тай байдаг явдал ч бас үүнтэй холбоотой(Basile, 1984). Бүсэд харьяалалтай гадаадын хөрөнгө оруулалттай

компаниуд орон нутгийн эмэгтэй ажилчдыг бага хэмжээгээр цалинжуулж, тэдний хөдөлмөрийг завшдаг мэтээр шүүмжлэлд өртөх нь бий. Гэвч эмэгтэй ажиллагсдын асуудалд зөвхөн цалин мөнгөний байр сууринаас хандах нь учир дутагдалтай. Тэдний хувьд экспортын чөлөөт бүсэд ажилласнаар шинэ боломжууд нээгдэх төдийгүй нийгмийн хариуцлага нь өндөрсдөг(Amirahmadi & Wu, 1995).

Экспортын чөлөөт бүсийг дандаа аар саархан үйл ажиллагаа явуулдаг газар мэтээр ойлгож болохгүй. Дэлхийн улс орнуудын жишээнээс харахад 1980-д оноос дэвшилтэт аж үйлдвэрийн салбарууд бүсийн хүрээнд орж ирэх болсон байна. UNCTAD(1993), Won Sun Oh(1993) нар судалгаандаа экспортын чөлөөт бүс “амьдралын мөчлөг”-тэй байдаг тухай тайлбарлаад дийлэнх бүсүүдэд энэхүү мөчлөг давтагддаг гэсэн байна. Бүс байгуулалтын эхэн үед цахилгаан бараа, гутал хувцас үйлдвэрлэл зонхилох бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт гол төлөв эдгээр салбаруудад л хийгдэнэ. Бүсийн үйл ажиллагаа идэвхжих үед эдгээр салбаруудын үйлдвэрлэл, экспортын хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ ч бас нэмэгдэнэ. Харин жигдрэх үед гадаадын хөрөнгө оруулалт, экспортын хэмжээ буурч үйлдвэрлэлийн зардал, ажилчдын ур чадвар нэмэгдэх бөгөөд нэмэгдсэн өртөг өндөртэй аж үйлдвэрүүдийн салбаруудын үйл ажиллагаа зонхилох болдог. Амьдралын мөчлөгийн эцсийн шатанд бүсийн “экспорт”-ын гэсэн онцлог нь суларч, шинэ үйл ажиллагааны чиглэлтэй зохицсон бүтцийн өөрчлөлт явагдах болдог. Бүсийн амьдралын мөчлөгтэй холбогдуулан авч үзэхэд мөчлөгийн шат ахих тусам эмэгтэй ажиллагсдын тоо буурдаг. Тухайлахад, Өмнөд Солонгосын Масаны чөлөөт худалдааны бүсийн эмэгтэй ажилчдын тоо түүний мөчлөгийн үе шаттай уялдан 90%(1971)-аас 75%(1981) болж буурч байжээ(McIntyre et al, 1996).

Дэвшилтэт технологи нэвтрүүлэх

Экспортын чөлөөт бүсийн компаниуд гаднаас тоног төхөөрөмж оруулах, ашиглах, засварлах, дотоодын нөхцөлд байдалд тохируулж шинэчлэх замаар шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлдэг. Бүсийн компаниуд үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ(R&D)-ний байгууламжаа нэг дор байрлуулан энэ үйл ажиллагаандаа дотоодын инженер, эрдэм шинжилгээний ажилтдыг оролцуулах үед технологийн шилжилт илүү бодитой түвшинд явагддаг.

Гэвч бодит амьдрал дээр бүсийн компаниуд дотоодын мэргэжилтнүүдийг үйлдвэрийн инженер, чанар шалгагчийн хэмжээнд авч ажиллуулах тал

ажиглагддаг. Тэд дотоодын үйлдвэрлэгчдээс үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт авах үед бүтээгдэхүүгийн чанарыг дэлхийн зах зээлийн чанарын түвшинд нийцүүлэх тухай шаардлагыг тавьдаг бөгөөд энэ шаардлагаа хэрэгжүүлэх үүднээс дотоодын нийлүүлэгчидтэй амархан ойлголцож, бүтээгдэхүүн нийлүүлэлт дээр нь хяналт шаардлага тавих чадвартай чанар шалгагч, инженерүүдийг авч ажиллуулах болдог.

Бүсийн технологи нэвтрүүлэлтийг дэмжих үүднээс бүсийн харьяа гадаадын компаниуд үйлдвэрлэлийн орц нийлүүлэх(backward linkage), бүсийн бүтээгдэхүүгийнг худалдан авах(forward linkage) тал дээр дотоодын компанитай хамтарч ажиллах үед инсентив олгодог улс орнууд бий. Мөн дотоодын инженер мэргэжилтнүүдэд зориулсан тусгай сургалт явуулах үед инсентив олгодог улс орнууд ч бий. Тухайлахад, Сингапурт бүсийн харьяа компани дэвшилтэт тоног төхөөрөмж, технологи оруулах үед засгийн газрын зүгээс тоног төхөөрөмж худалдан авах, инженер техникийн сургалт явуулах тал дээр санхүүжилт хийдэг.

Экспортын чөлөөт бүсийн технологийн ач холбогдлын талаарх судалгаанууд энэ асуудалд хоёрдмол байр сууринаас ханддаг. Globerman(1979), Nadiri(1991) нар бүсийн компаниудын технологи нэвтрүүлэлт тухайн орны үйлдвэрлэлийн бүтээмжинд нөлөөлдөг гэсэн байхад Cantwell(1989), Haddad&Harrison(1991) нар бүсийн технологи нэвтрүүлэлт бүх аж үйлдвэрийн салбарын хэмжээнд нөлөө үзүүлж чаддаггүй гэсэн байна. Kokko(1992) судалгаандаа дотоодын болон гадаадын компаний технологийн түвшиний зөрүү(technological gap)-ээс хамаарч бүсийн технологийн эдийн засгийн үр нөлөө янз бүр байна гээд зөрүү бага байх тусам шинэ технологийн эдийн засгийн үр нөлөө их байдаг тухай тайлбарласан байна.

Дийлэнх экспортын чөлөөт бүсэд цахилгаан бараа угсрах, гутал хувцас үйлдвэрлэх аж үйлдвэр зонхилдгоос хэрэглэхэд хялбар, өргөн тархсан технологи орж ирдэг. Түүнчлэн бүсийн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд ихэнхдээ үйлдвэрлэлийн зардал хэмнэх(efficiency-seeking) замаар бүтээгдэхүүгийн үнийн өрсөлдөх чадварыг бий болгох(price competitiveness) зорилготой байдгаас тэргүүний шилдэг технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмж, ажилтдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх асуудалд хайхрамжгүй ханддаг. Тиймээс ч экспортын чөлөөт бүсийн ажиллах хүчний мэргэжлийн ур чадвар байнга нэг түвшинд байдаг тухай Sadni-Jallab&Blanco de Armas(2002) нарын судалгаа харуулсан байдаг. Мексикийн *maquila*-гийн

үйлдвэрлэлийн бүтээмж 1988-1998 оны хооронд 0.6% өссөн байхад *non-maquila*-д 30% хүрч өссөн байна. Үүнийг *maquila*-ийн компаниуд экспортын үйлдвэрлэлд шаардлагатай дийлэнх эд хэрэгслийг гаднаас импортлохоос гадна мэргэжлийн бус хямд төсөр ажиллах хүчин дээр тулгуурлаж үйл ажиллагаа явуулдагтай нь холбож тайлбарласан байна.

Түүнчлэн экспортын чөлөөт бүсэд судалгаа шинжилгээний үйл ажиллагаа бараг явагддаггүй. Компаний менежмент стратеги(*corporate strategy*)-ын хүрээнд үндэстэн дамнасан корпорацийн судалгаа шинжилгээний ажиллагааг удирдах төвөөс нь шууд хариуцаж явуулахын зэрэгцээ судалгааны байгууллагыг өөрийн эх орондоо байлгадаг. Үүнээс гадна үндэстэн дамнасан корпораци “компани дотоодын арилжаа солилцооны сүлжээ(*intra-firm transaction*)”-ээр дамжуулж үйлдвэрлэлээ явуулдгаас дотоодын үйлдвэрлэгчидтэй гэрээ байгуулж хамтран ажиллах шаардлага багатай байдаг. Хамтран ажиллах тохиолдолд(завсрын бараа нийлүүлэх гэрээ байгуулах(*subcontract on the intermediate goods supply*) г.м.) гол төлөв жижиг дунд үйлдвэрүүдтэй богино хугацаанд гэрээ байгуулж ажилладаг. Тэд бүс байгуулагч улсын худалдааны харьцангуй давуу тал(*comparative advantage*)-ыг ашиглаж богино хугацаанд их хэмжээний ашиг олох зорилготой байдгаас урт хугацаанд гэрээ байгуулах сонирхолгүй байдаг.

Бүсийн харьяа гадаадын компаниудын үйл ажиллагааг дотоодын аж үйлдвэрийн зарим нэг салбараас тусгаарлах засгийн газрын арга хэмжээ бүсийн технологи нэвтрүүлэлтэд таагүй нөлөө үзүүлдэг(UNCTAD, 1985). Энэ байдал нь дотоодын аж үйлдвэрүүдийн хүрээнд бүсийн бүтээгдэхүүн нийлүүлэлт, худалдан авахтай холбоотой эдийн засгийн үр нөлөө бий болоход саад болдог.

Гадаад валютын орлого ашгийг нэмэгдүүлэх

Гадаад валютын ашиг орлогыг нэмэгдүүлэх нь экспортын чөлөөт бүсийн зүй ёсны зорилгод орно. Гадаад валютын ашиг орлогыг цэвэр экспортын хэмжээ¹, бүсийн нэмэгдсэн өртгийн нийлбэр дүнгээр тооцож гаргадаг боловч үүнтэй холбоотой статистик тоо баримт дутагдалтай байдаг(FIAS, 2008).

Экспортын чөлөөт бүсийн нэмүү өртгийн хэмжээ бүсийн бүтээгдэхүүн дотоодын зах зээл дээр борлогдох үед, мөн бүсийн компаниуд дотоодын үйлдвэрлэгчдээс үйлдвэрлэлийн орц(завсрын бараа, түүхий эд г.м.)-ын

¹ Нийт экспортын хэмжээнээс нийт импортын хэмжээг хасч гаргасан дүн.

нийлүүлэлт авах үед нэмэгдэнэ. 2000 онд Өмнөд Солонгосын чөлөөт бүсүүдийн цэвэр экспортын хэмжээ өмнөх жилүүдээс 60% өсч байсан(Schrank, 2001)-ыг бүсийн компаниуд дотоодын аж үйлдвэрийн салбаруудтай хамтарч ажилласантай холбон тайлбарлажээ(Healey and Lutkenhorst, 1989).

FIAS(2008) дараах хүчин зүйлсийг бүсийн гадаад валютын орлого нэмэгдэхэд саад болдог гэж тодорхойлсон байна.

- ✧ Экспортын үйлдвэрлэлийн орцыг хилийн чанадаас импортлох байдал
- ✧ Гадаадад боловсруулалт хийх горим(outward processing relief) г.м. худалдааны нөхцлийн талаарх хэлэлцээрүүд
- ✧ Бүсийн бүтээгдэхүүгийн дотоодын зах зээл дээр борлуулахад хязгаарлалт хийх явдал
- ✧ Дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэл, технологи, менежментийн нөү хау г.м. үнийн бус өрсөлдөх чадвар муу байх
- ✧ Бүсийн компаниуд глобал сорсинг стратегийн дагуу үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлтийг дотоодын үйлдвэрлэгчдээс бус олон улсын сүлжээгээр авах явдал
- ✧ Дотоодын боломжит үйлдвэрлэгчдийн талаарх мэдээлэл сурталчилгаа, тэдэнтэй зуучлах үйлчилгээ дутагдалтай байх

III. Экспортын чөлөөт бүсийн зорилгын хэрэгжилт ба зардал ашгийн дүн шинжилгээ

Экспортын чөлөөт бүс эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх хэрэгслүүдийн нэг байдаг. Учир нь бүсийн хүрээний гадаадын хөрөнгө оруулалт эдийн засгийн олон талт үр нөлөөг бий болгох бөгөөд эдгээр үр нөлөө нь макро түвшинд эдийн засгийн хөгжлийн бааз суурь болдог.

Бүс байгуулах ажил асар их хэмжээний төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг шаарддаг. Тиймээс бүс байгуулах эсэхийн талаарх шийдвэр гаргах үйл явцад нийт орох зардал, түүнээс бий болох ашгийн хэмжээний талаар нарийн судлах шаардлагатай байдаг. Нэг үгээр бүсийн ашгийн хэмжээ зардлын хэмжээг давах үед бүс байгуулах ажил явагдах ёстой гэсэн үг юм. / Зураг 1./

Зураг 1. Экспортын чөлөөт бүсийн зорилго ба зардал ашгийн харьцаа



Экспортын чөлөөт бүсийн зардлын тухайд энэ нь байгуулалтын зардал(дэд бүтцийн байгууламж, бүсийн оршин суугчдын орон сууц, нийгмийн халамж, эмнэлэг сургууль байгуулахтай холбоотой буюу ‘хөдөө газрыг хот суурин болгох’ ажиллагаа), санхүүгийн болон татварын инсентив(гаалийн татвараас хөнгөлөх, мөнгөн тэтгэмж олгох), захиргаа ашиглалтын зардал(нэг цэгт үйлчилгээ, харуул хамгаалалт, мэргэжлийн хяналт) зэрэг төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалт болно. Бүсийн ажиллагаа ‘өртөг нөхөгдөх’ нөхцлөөр явагдах үед зардал харьцангуй бага тусна. Экспортын чөлөөт бүсийн зардлыг бүс байгуулах үеийн зардлаар тооцох хандлага байдаг. Энэ бол учир дутагдалтай. Бүсийн ашиглалт, хөрөнгө оруулалтын инсентивтэй холбоотой урсгал зардлыг зайлшгүй тооцох ёстой.

Экспортын чөлөөт бүсийн ашгийн тухайд ажил эрхлэлт нэмэгдэхтэй холбоотой эдийн засгийн ач холбогдол(цалин, хөдөлмөрийн боломжит зардлын зөрүү, ажилтны орлого), технологи нэвтрүүлэлтээс бий болох эдийн засгийн үр нөлөө(үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт, технологийн дэвшил), засгийн газрын төсвийн орлого(татварын орлого), экспортын өсөлтөөс бий болох гадаад валютын ашиг орлого(цэвэр экспорт, нэмэгдсэн өртгийн нийлбэр) зэрэг багтана. Бүс байгуулалтын ашиг зардлын дүн шинжилгээ нь бүс байгуулалт ашиглалттай холбоотой бүх зардал болон бүсийн эдийн засгийн үр ашгийг мөнгөн дүнгээр тооцож тухайн бүсийн эдийн засгийн байдлыг тодорхойлоход чиглэдэг. Гэвч энэ дүн шинжилгээ сүүдрийн үнэ, нийгмийн хямдралын хувь г.м. хүчин зүйлсийг багцаалсан аргачлал дээр хийгддэг, чанарын үзүүлэлтийг тоон үзүүлэлтээр илэрхийлдэг гэсэн талаасаа учир дутагдалтай.

Уг судалгаа бүс байгуулалттай холбоотой зардал ашгийн дүн шинжилгээг хийхгүй, зардал ашгийн харьцаан дээр үндэслэн бүсийн эдийн засгийн бодит үр нөлөөний талаар судлахад чиглэнэ. Нэг үгээр асар их хэмжээний төсвийн зарцуулалттай харьцах бүсийн эдийн засгийн үр ашгийн харьцаа бодит амьдрал дээр ямар байдаг талаар авч үзэх болно.

Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх

Ажлын байр бий болгох зорилгоор засгийн газрын зүгээс бүсийн байгуулалт ашиглалтанд ихээхэн хэмжээний санхүүжилт хийдэг. Зарим тохиолдолд энэ нь газар тариалангийн салбар, дотоодын жижиг дунд үйлдвэрүүдийн хүрээнд ажлын байр бий болгохоос хэд дахин илүү хэмжээгээр тусах нь бий. 1970-1982 онд Өмнөд Солонгосын засгийн газар Масаны Худалдааны Чөлөөт Бүс байгуулах төсөлд 118 сая ам.доллар зарцуулсан нь нийт 30,000 ажлын байр бий болгоход чиглэж байв. Энэ төслийн хүрээнд нэг ажлын байр бий болгоход 5,000 ам.доллар зарцуулагдсан бөгөөд тухайн үеийн барааны үнэ, цалингийн түвшинтэй харьцуулахад багагүй хэмжээний зардал байв(Rondinelli, 1987). Филиппиний засгийн газар 1983 онд экспортын гурван чөлөөт бүс байгуулах төсөлд нийт 352 сая ам.доллар зарцуулсан бөгөөд эдгээр гурван бүсэд нийт 30,574 ажлын байр шинээр бий болсон нь нэг ажлын байр бий болгоход 11,354 ам.долларын төсөв зарцуулагдсан гэсэн үг юм(McIntyre et al, 1996).

Бүс байгуулалттай холбоотойгоор төсвийн хөрөнгө оруулалтын боломжит зардлын тооцоо хийгдэх шаардлагатай байдаг. Warr(1983) нэг ажилгүй хүнийг ажилтай болгосноос бий болох цэвэр ашгийг ажилтны цалин, боломжит зардлын зөрүүгээр тооцно гээд бүсийн хүрээнд нэг ажлын байр бий болгоход орох зардал эдийн засгийн өөр салбарт нэг ажлын байр бий болгоход хэрхэн тусахыг тооцох хэрэгтэй гэжээ.

Мөн бүсийн компаниуд ихэнхдээ өөрсдийн мэргэжилтнийг гаднаас авч ажиллуулдагаас мэргэжлийн боловсон хүчний ажил эрхлэлтээс бий болох цэвэр ашгийн хэмжээ 0-тэй ойролцоо байдаг байна(McIntyre et al, 1996).

Дэвшилтэт технологи нэвтрүүлэх

Дэвшилтэт технологийн шилжилт биет ба биет бус хэлбэрээр явагдана. Биет бус хэлбэрийн шилжилтийн тухайд бүсийн үйл ажиллагаа мэргэжилийн ур чадвар шаарддаггүй, хямд төсөр ажиллах хүчинд тулгуурлан нэмэгдсэн өртөг багатай үйлдвэрлэл дээр явагддагаас бага түвшинд байдаг. Бүсийн техник технологийн сургалтын агуулга гол төлөв үйлдвэрлэлийн зарчим, ажлын дэг журамтай

холбоотой байдгаас биет бус хэлбэрийн технологи шилжилт явагдахад дорвитой нөлөө үзүүлдэггүй байна(UNCTAD, 2002).

Биет хэлбэрийн шилжилтийн тухайд технологийн хөгжил сул дорой улсад эдийн засгийн өгөөж багатай, хэрэглээнээс гарч буй тоног төхөөрөмж очдог. Гэвч эдгээр тоног төхөөрөмж бүс байгуулагч улсын технологийн эрэлт хэрэгцээг хангах, аль эсвэл тэд үүнээс суралцах, гүйцэж тэнцэх бодлого баримтлах үед бага зэрэг хоцрогдсон технологи авч ашиглахад гарздах зүйлгүй(Narula, 1991). Нөгөөтэйгүүр бүсэд хамгийн сүүлийн үеийн технологи, тоног төхөөрөмж орж ирвэл тухайн улсын ажиллах хүчний эрэлт хэрэгцээ буурч, өндөр хөлс өртөгтэй гадны мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэнэ. Аж үйлдвэр, эдийн засгийн хөгжил, үүнтэй уялдаатай бий болох техник технологийн эрэлт хэрэгцээг урьдчилан таамаглахад хүндрэлтэй байдгаас технологи нэвтрүүлэлтийн эдийн засгийн ач холбогдлыг ашиг зардлын талаас тооцоход хүнд байдаг.

Гадаад валютын ашиг орлогыг нэмэгдүүлэх

Бүсийн үйлдвэрлэлийн орц гаднаас импортоор орж ирдэгээс экспортын ашгийн нилээд хэсэг импортын зардлыг тэглэхэд зарцуулагдах нь бий. Мөн цэвэр экспортын дүнг тооцоход зээлийн нөхөн төлбөр, хөрөнгийн элэгдэл хорогдлын тооцоо ордоггүй байна(McIntyre et al, 1996).

IV. Дүгнэлт

Улс орнууд ажил эрхлэлт нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор экспортын чөлөөт бүсийг байгуулдаг бөгөөд энэ зорилгондоо хүрэх үүднээс дэд бүтэц байгуулах, санхүүгийн болон татварын инсентив олгох зэрэг бүс байгуулалттай холбоотой асар их хэмжээний төсвийн зарцуулалт хийдэг. Нэг үгээр экспортын чөлөөт бүсийн эдийн засгийн ашгийг бий болгох үүднээс их хэмжээний төсвийн зардал гаргадаг.

Бодит байдал дээр экспортын чөлөөт бүсийн зардалтай харьцах ашгийн хэмжээний талаар авч үзэхэд нэгд, бүсийн ажил эрхлэлт гол төлөв нарийн мэргэжил, ур чадвар шаарддаггүй, хямд төсөр ажиллах хүчин нэн ялангуяа эмэгтэй ажилчдын хүрээнд бий болдог байна. Хоёрт, дийлэнх экспортын чөлөөт бүсэд цахилгаан бараа угсрах, гутал хувцас үйлдвэрлэх аж үйлдвэр зонхилдгоос хэрэглэхэд хялбар, өргөн тархсан технологи орж ирдэг. Экспортын чөлөөт бүсэд судалгаа шинжилгээний үйл ажиллагаа бараг явагддаггүйгээс гадна бүсийн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд ихэнхдээ үйлдвэрлэлийн зардал

хэмнэх зорилготой байдгаас тэргүүний шилдэг технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмж, ажилтдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх асуудал орхигддог. Гуравт, бүсийн үйлдвэрлэлийн орц гаднаас импортоор орж ирдэгээс гадаад валютын ашгийн нилээд хэсэг импортын зардлыг тэглэхэд зарцуулагдах нь бий.

Улмаар уг судалгаа экспортын чөлөөт бүсийн ашиг зардлаас илүү байхад нөлөөлөх бодлогын чанартай хэдэн асуудлыг дэвшүүлэхийг зорив.

Нэгт, ажил эрхлэлт, дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, гадаад валютын ашиг орлоготой холбоотой бүсийн үүрэг хариуцлагыг эдийн засгийн бодлогын стратегийн хүрээнд нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Бодит амьдрал дээр экспортын чөлөөт бүс байгуулалт, ашиглалтын зорилго тодорхой байж чаддаггүй байна(Baissac, 1996).

Хоёрт, ажил эрхлэлт, дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, гадаад валютын ашиг орлого г.м. бүсийн эдийн засгийн үр нөлөөг бий болгох асуудал тухайн улсын засгийн газрын хариуцах асуудал болохоос тэнд үйл ажиллагаа явуулж буй гадаадын компаниудын үүрэг хариуцлага огтоос биш. Тиймээс бүсийн компаниудад эдийн засгийн үр нөлөөтэй холбоотой шаардлага тавьж, түүнтэй холбоотой тэдний хүсэлтийг инсентив зэрэгт тусгах нь зүйтэй. Хөрөнгө оруулагчдын тухайд хөрөнгө оруулалтын хэсэгхэн хугацааны инсентив тэтгэлэгээс илүү хөрөнгө оруулалтын бүхий л хугацааны ашгийн батлан даалт чухал байдаг. Энэ утгаараа бүсийн компаниудын бүтээгдэхүүгийн дотоодын зах зээл дээр борлуулах эрх олгох зэрэг хөрөнгө оруулалтын орчны арга хэмжээ илүү тусгацтай байж болох юм.

Гуравт, экспортын чөлөөт бүсийн бодлогод уян хатан байдлаас хандах шаардлагатай. Бүсийн үйл ажиллагааны чиглэлд тухайлахад, бүсийн амьдралын мөчлөгтэй ч юм уу холбоотой өөрчлөлт орох үед ажил эрхлэлт, дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, гадаад валютын ашиг орлого г.м. бүсийн эдийн засгийн үр нөлөөтэй холбоотой бодлогын чанартай өөрчлөлтүүдийг давхар хийх нь зүйтэй.

Ном зүй

- Basile, A. (1984). *Investing in Freeport Processing Zones*, Paris: OECD.
ESCAP/UNCPE. (1985). *An Evaluation of Export Processing Zones in Selected Asian Countries*, Bangkok: United Nations.

- FIAS. (2008). *Special Economic Zones Performance, Lessons Learned, and Implications for Zone Development*, April 2008, The Office of the Publisher, The World Bank W.D.C.
- Healey, D., and W. Lutkenhorst. (1989). Export Processing Zones: The Case of the Republic of Korea. *Industry and Development* 26:1–56.
- Kokko, A. (1992). *Foreign Direct Investment: Host Country Characteristics and Spillovers*, Stockholm: Economic Research Institute, Stockholm School of Economics.
- Madani, D. (1999). *A Review of the Role and Impact of Export Processing Zones*, World Bank Development Research Group Policy Research Working Paper 2238 (November).
- McIntyre, John R., Narula, Rajneesh and Trevino, Len J. (1996). The Role of Export Processing Zones for Host Countries and Multinationals: A Mutually Beneficial Relationship?, *The International Trade Journal*, 10: 4, 435-466.
- Nadiri, M. (1991). *US Direct Investment and the Production Structure of the Manufacturing Sector in France, Germany, Japan and the UK*, Mimeo, Washington, D.C., NBER.
- Rondinelli, D.A. (1987). Export Processing Zones and Economic Development in Asia, *American Journal of Economics and Sociology*, Vol. 46, No. 1, 89-105.
- Schrank, A. (2001). Export Processing Zones: Free Market Islands or Bridges to Structural Transformation?, *Development Policy Review*, 19(2): 223–242.
- Sadni-Jallab, M., and E. Blanco de Armas. (2002). *A Review of the Role and Impact of Export Processing Zones in World Trade: The Case of Mexico*, Institute of Development Studies, Brighton.
- UNCTAD. (1985). *Export Processing Free Zones in Developing Countries: Implications for Trade and Industrialization Policies*, United Nations, New York.
- UNCTAD. (1993). *Export Processing Zones: Role of Foreign Direct Investment and Development Impact*, United Nations, Geneva.
- UNCTAD. (2002). *World Investment Report 2002: Transnational Corporations and Export Competitiveness*, United Nations, New York.
- Warr, Peter G. (1983). The Jakarta Export Processing Zone: Benefits and Costs, *Bulletin of Indonesian Economic Studies*. December.